



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/365

Булган

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Б.Цэвэгмид /ГЭ74041013/-ийн Булган сум 6-р баг Залуус 8-р гудамж 800 тоотод байршилтай 6308002896 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 600 метр квадрат газар нь кадастрын зураглалаар 672 метр квадрат, Т.Янжинлхам /ГЮ86111007/-ын Булган сум 6-р баг 8-р гудамж 814 тоотод байршилтай 577 метр квадрат газар нь 598 метр квадрат болж өөрчлөгдсөн тул кадастрын зургийн дагуу шинэчлэн эзэмшүүлсүгэй.

2. Б.Цэвэгмид, Т.Янжинлхам нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны Б/59 дүгээр захирамжийн Т.Янжинлхамтай, Булган сумын Засаг даргын 2010 оны 76 дугаар захирамжийн Б.Цэвэгмидтэй холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ